



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 256

Улаанбаатар хот

Г Тусгай зөвшөөрлийн хүсэлтийг Г
хүлээн авахыг түр зогсоох тухай

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсантай холбогдуулан цаашид мэргэжлийн зуучлагч байгууллагуудад тавигдах шалгуурыг өөрчлөх бодлогын дагуу түүнд нийцүүлэн дүрэм, журам, зааврыг боловсруулах ажлыг хэрэгжүүлж байгааг ТЭМДЭГЛЭН, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.2 дахь заалт, Хорооны 2013 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхээр тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг хүлээн авахыг 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагаар түр зогсоосугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН